



САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН РЕКТОРЫН  
ТУШААЛ

2026 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/62

Улаанбаатар хот

Шинэ элсэгчийн тэтгэлэг олгох  
журам батлах тухай

Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн Ректорын тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийн элсэлтийн нэгдсэн бодлогод тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Бакалаврын зэрэг олгох хөтөлбөрт шинэ элсэгчийн тэтгэлэг олгох журам”-ыг хавсралт №1-ээр баталсугай.

2. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан тэтгэлэг олгох үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг элсэлтийн комиссын дарга (Б.Мөнхзаяа)-д, тэтгэлгийн материал хүлээн авах системийн бэлэн байдлыг хангаж хяналт тавьж ажиллахыг мэдээлэл технологийн албаны дарга (Б.Батжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3. 2026-2027 оны хичээлийн жилд шинэ элсэгчийн тэтгэлэг олгох журмын холбогдох зардлыг зохих төсвөөс зарцуулахыг Эдийн засаг, санхүүгийн албаны дарга (Д.Өлзиймаа)-д зөвшөөрсүгэй.

РЕКТОР  Б.МӨНХБАЯР





## ШИНЭ ЭЛСЭГЧИЙН ТЭТГЭЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.СЭЗИС-ийн “оюутан элсүүлэх журам”-ыг үндэслэн сурлагын амжилт гаргасан, суралцах хүсэл эрмэлзэлтэй элсэгчдэд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, суралцах идэвх, урам зоригийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү тэтгэлгийг олгоно.

1.2.Манлайлагч болон зорилтот бүлгийн элсэгчдэд тус бүр 3,000,000 (гурван сая) хүртэлх төгрөгийн (шалгуураас хамааран) сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

1.3.ВТЕС Talent тэтгэлэгт хөтөлбөр нь элсэгчдэд тус бүр 5,000,000 (таван сая) хүртэлх төгрөгийн (шалгуураас хамааран) сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

1.4.Энэхүү журам нь тэтгэлэг горилогчид тавигдах шаардлагыг тодорхойлох, хүсэлт гаргах, сонгон шалгаруулах, тэтгэлэг олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

1.5.“Тэтгэлэг горилогч” гэж энэхүү журмын 2 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан элсэгчийг ойлгоно.

1.6.“Тэтгэлгийн комисс” гэж элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор СЭЗИС-ийн Ректорын тушаалаар байгуулсан ажлын хэсгийг ойлгоно.

### Хоёр.Тэтгэлгийн шалгуур, бүрдүүлэх материал

2.1.Манлайлагч элсэгчийн тэтгэлэг: Сурлагын өндөр амжилттай, манлайллын ур чадвартай, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх чадвартай элсэгчид нэг удаа олгодог сургалтын төлбөрийн тэтгэлэг юм.

Тэтгэлэгийн шалгуур	Бүрдүүлэх материал, хүсэлт гаргах
1.Боловсролын гэрчилгээний дундаж үнэлгээ 90 ба түүнээс дээш байх; 2.Сурагчдын зөвлөл, клуб, холбоо болон нийгэм, олон нийтийн үйл ажиллагаанд манлайлан оролцож, удирдах үүрэг гүйцэтгэж байсан туршлагатай байх; 3.Олон улсын хүүхдийн уралдаан, тэмцээнд амжилт гарган шагналт байр эзэлсэн байх; Дээрх үйл ажиллагааг нотлох баримт бичиг, тодорхойлолт, гэрчилгээтэй байх.	1.Эсээ:(800-850 үгтэй) дараах агуулгыг тусгасан байна. Эсээг горилогч өөрийн үгээр бичсэн, эх бүтээл байна . ✓ СЭЗИС болон сонгосон мэргэжлийн үндэслэл; ✓ Сурах чин эрмэлзэл, карьерын төлөвлөгөө; ✓ Сурлага болон нийгэмд тустай ажлыг манлайлан оролцож байсан 3 бодит жишээ; 2.Сурлагын амжилтыг нотлох баримт (гэрчилгээ, дүнгийн хуулбар гэх мэт)

	<p>3.Сайн дурын болон олон нийтийн үйл ажиллагаанд оролцсон нотлох баримт;  4.Өөрийн товч танилцуулга видео (1минут хүртэл) Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Суралцах зорилго</li> <li>✓ Давуу тал</li> <li>✓ Манлайллын ур чадвар</li> </ul>
--	---

2.2.Зорилтот бүлгийн элсэгчийн тэтгэлэг: Нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой нөхцөл байдалд байгаа элсэгчдэд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаа олгодог сургалтын төлбөрийн тэтгэлэг юм.

Тэтгэлэгийн шалгуур	Бүрдүүлэх материал, хүсэлт гаргах
<p>1.Өрх толгойлсон, асран хамгаалагчаа алдсан, эсвэл 4 ба түүнээс дээш хүүхэдтэй гэр бүлийн гишүүн байх;  2.Тусгай хэрэгцээт (хөгжлийн бэрхшээлтэй) элсэгч байх;  3.Эцэг, эх асран хамгаалагчийн аль нэг нь хөгжлийн бэрхшээлтэй (хөдөлмөрийн чадвараа 50 хүртэл хувиар алдсан);  4.Асрамжийн газрын харьяалалтай элсэгч хамаарна.</p>	<p>1.Эсээ (800-850 үгтэй) дараах агуулгыг тусгасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ СЭЗИС болон сонгосон мэргэжлийн үндэслэл;</li> <li>✓ Сурах чин эрмэлзэл, карьерын төлөвлөгөө;</li> <li>✓ Сургуулиа төгсөөд нийгэмд оруулах 3 гол хувь нэмэр;</li> </ul> <p>2.Сурлагын амжилтыг нотлох баримт;  3.Зорилтот бүлэгт хамаарахыг нотлох баримт;  4.Өөрийн товч танилцуулга видео (1 минут хүртэл)</p>

2.3.ВТЕС Talent тэтгэлэг: Олон улсын диплом олгох ВТЕС Higher Nationals хөтөлбөрт суралцах чин эрмэлзэлтэй, авьяаслаг элсэгчдийг санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаа олгодог сургалтын төлбөрийн тэтгэлэг юм.

Тэтгэлэгийн шалгуур	Бүрдүүлэх материал, хүсэлт гаргах
<p>1.Бүрэн дунд боловсролын гэрчилгээтэй эсвэл ВТЕС 3-р түвшний (Level 3) зэрэгтэй байх.  2.Хөтөлбөр англи хэл дээр явагддаг тул IELTS 6 (унших, бичих чадвар 5.5-аас доошгүй)  3.Бизнес эсвэл Дижитал технологийн (Дата аналитик) чиглэлээр суралцаж,</p>	<p>1.Эсээ: (500-аас доошгүй үгтэй) дараах агуулгыг тусгасан байна. Эсээг гориллогч өөрийн үгээр бичсэн, эх бүтээл байна .</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Яагаад СЭЗИС-ийн ВТЕС олон улсын хөтөлбөрийг сонгосон бэ?</li> <li>✓ Энэ хөтөлбөр таны ирээдүйн карьерт хэрхэн нөлөөлөх вэ?</li> <li>✓ Та өөрийгөө бие даан судалгаа хийх, цаг төлөвлөх чадвартай гэдгээ хэрхэн нотлох вэ?</li> </ul>

<p>тухайн салбартаа манлайлах чин хүсэлтэй байх.</p> <p>4. ВТЕС хөтөлбөр нь зөвхөн даалгаварт суурилсан сургалт тул бие даан судалгаа хийх, цаг төлөвлөх чадвартай байх</p>	<p>✓ Сурлага болон нийгэмд тустай ажлыг манлайлан оролцож байсан жишээ;</p> <p>2. Сурлагын амжилтыг нотлох баримт (гэрчилгээ, дүнгийн хуулбар гэх мэт)</p> <p>3. Англи хэлний түвшин тогтоох шалгалтын батламж (IELTS/PTE г.м)</p> <p>4. Өөрийн товч танилцуулга видео (1 минут хүртэл) Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Суралцах зорилго</li> <li>✓ Давуу тал</li> <li>✓ Манлайллын ур чадвар</li> </ul>
---	---

2.4. Хүсэлт гаргах: Тэтгэлэг горилогч нь шаардлагатай материалыг бүрдүүлэн 2026 оны 04 сарын 22-ы өдрөөс 06 сарын 13-ы өдрийг дуустал элсэлтийн цахим систем ([admission.ufe.edu.mn](http://admission.ufe.edu.mn)) сайтаар хүлээн авна.

Мэдээлэл авах, холбоо барих албан ёсны сувгууд:

1. Цахим шуудан (И-мэйл): [Admission\\_bachelor@ufe.edu.mn](mailto:Admission_bachelor@ufe.edu.mn)
2. Лавлах утасны дугаарууд: 85058035, ВТЕС talent тэтгэлэг: 99902286, 99189137

#### Гурав. Тэтгэлгийн сонгон шалгаруулалт, гардуулалт

3.1. Тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг хоёр үе шаттайгаар зохион байгуулна.

Нэгдүгээр шат: Ирүүлсэн материалд үнэлгээ хийж, ярилцлагын шатанд оролцох тэтгэлэг горилогчийг шалгаруулна. Бүрдүүлэлт дутуу болон хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй.

Хоёрдугаар шат: Нэгдүгээр шатанд тэнцсэн элсэгч ярилцлагад орж, үнэлгээгээр тэнцсэн тохиолдолд тэтгэлэг авах эрх үүснэ.

3.2. СЭЗИС-ийн элсэлтийн шаардлагыг ханган, суралцах гэрээ байгуулсан элсэгчид тэтгэлгийг нэг удаа олгоно.

#### Дөрөв. Бусад

4.1. Тэтгэлэг авсан элсэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр СЭЗИС-д суралцаагүй тохиолдолд олгосон тэтгэлгийг буцаан төлөх үүрэгтэй.

4.2. Сонгон шалгаруулалтын явцад ашиг сонирхлын зөрчил үүссэн, баримт бичиг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдээлэл өгсөн нь тогтоогдсон тохиолдолд тэтгэлгийг хүчингүйд тооцно.

4.3. Энэхүү журмаар зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, СЭЗИС-ийн дотоод дүрэм, журмаар зохицуулна.